

ЗОХИЦУУЛАХ ХОРОО БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДУУЛАН

1948 ОНЫ 3 ДУГААР САРЫН 6-НЫ ӨДӨР БАТЛАГДСАН ДАЛАЙН ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ ОЛОН УЛСЫН КОНВЕНЦИД ОРУУЛСАН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ

Албан хэрэг хөтлөлтийг хөнгөвчлөн 6.2.1.х, хялбарчлах хороо /цаашид
“Зохицуулах хороо” гэх/ байгуулах талаар Далайн олон улсын байгууллагын
конвенцид нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Далайн Олон Улсын байгууллагын
шийдвэр № А.724 /17/
/1991 оны 11 дүгээр сарын 7/

Хэлэлцсэн асуудлын 15 дахь заалт

Ассамблей, Зохицуулах хороо байгуулах асуудлаар Далайн олон улсын байгууллагын конвенцид оруулах нэмэлт, өөрчлөлтийг хүлээн зөвшөөрөх талаар арван долдугаар ээлжит чуулганаараа шаардлагатай арга хэмжээ авах тухай хүлээн зөвшөөрч баталсан арван зургадугаар ээлжит чуулганыхаа А.640(16) шийдвэрээ удирдлага болгож,

Зохицуулах хорооноос санал болгосон Далайн олон улсын байгууллагын конвенцид оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн зөвлөмж ба эдгээр зөвлөмжийн талаарх Зөвлөлийн санал, дүгнэлтийг хянан хэлэлцээд,

1. Далайн олон улсын байгууллагын конвенцид оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хүлээн зөвшөөрснөөр, тэдгээрийн эх бичвэр энэхүү шийдвэрийн хавсралтад агуулагдаж дор дурдсанаас бүрдэнэ:

- 11, 15, 21, 56 ба 57 дугаар зүйлүүдэд оруулсан нэмэлт, өөрчлөлтүүд;
- "XI Хэсэг"-т 47-51 дүгээр шинээр нэмсэн зүйлүүдээс бүрдэж буй шинэ хэсгийг нэмэх;
- одоогийн XI - XX хэсгүүдийг зохих ёсоор шинэчлэн дугаарлах;
- одоогийн 47-77 дугаар зүйлүүдийг зохих ёсоор шинэчлэн дугаарлах;
- 5, 6, 7, 8, 66, 67, 68, 70, 72, 73 ба 74 дүгээр зүйлүүдэд зохих ёсоор шинэчлэн дугаарлагдсан зүйлүүдийг үндэслэн зохих өөрчлөлт оруулах;
- 15 ба 25 (а) зүйлүүдэд шинэчлэн дугаарлагдсан хэсгийг үндэслэн зохих өөрчлөлт оруулах;

- нэмэлт II хавсралтад тусгагдсан шинэчлэн дугаарлагдсан зүйлүүдийг зохих ёсоор өөрчлөн дугаарлах;

2. Далайн олон улсын байгууллагын конвенцийн 72 дугаар зүйл (өмнө нь 67 дугаар зүйл)-д нийцүүлэн хүлээн зөвшөөрч, баталсан нэмэлт өөрчлөлтийг хадгалуулахаар НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргад хүргүүлэх, 73 дугаар зүйл (өмнө нь 68 дугаар зүйл) -д урьдчилан заасны дагуу хүлээн авснаа мэдэгдсэн тунхаг баримт авахыг Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргаас хүсч,

3. Далайн олон улсын байгууллагын конвенцийн 73 дугаар зүйл (өмнө нь 68 дугаар зүйл) –ийн дагуу хүлээн зөвшөөрсөн тухай тунхаг баримтын хуулбарыг Ерөнхий нарийн бичгийн даргаас хүлээн авсны дараа энэхүү нэмэлт өөрчлөлтийг аль болох богино хугацаанд хүлээн зөвшөөрөхийг гишүүн орнуудын Засгийн газруудад уриалав.

11 дүгээр зүйл

Эх бичвэр дараахь байдлаар солигдоно:

“Байгууллага нь Ассамблей, Зөвлөл, Далайд аюулгүй байдлыг хангах Хороо, Хуулийн Хороо, Далайн орчныг хамгаалах Хороо, Техникийн хамтын ажиллагааны Хороо, Зохицуулах Хороо болон шаардлагатай бол Байгууллага дурын үедээ шүүн хэлэлцэх салбар, туслах байгууллага түүнчлэн Нарийн бичгийн дарга нарын газраас бүрдэнэ.

15 дугаар зүйл

“1” заалтын эх бичвэр дараахь байдлаар солигдоно:

“1) Далайд аюулгүй байдлыг хангах Хороо, Хуулийн Хороо, Далайн орчныг хамгаалах Хороо, Техникийн хамтын ажиллагааны Хороо, Зохицуулах Хороо болон бусад Байгууллагуудаас боловсруулсан олон улсын гэрээ, конвенциуд ба олон улсын аливаа гэрээ, конвенцид оруулах нэмэлт, өөрчлөлтийг хүлээн зөвшөөрч батлах зорилгоор бусад дурын зохих ёс горим, журам зааврыг хэрэглэх болон олон улсын аливаа бага хурлыг зарлан хуралдуулахтай холбогдсон шийдвэр гаргана.

21 дүгээр зүйл

Эх бичвэр дараахь байдлаар солигдоно:

(а) Зөвлөл нь Далайд аюулгүй байдлыг хангах Хороо, Хуулийн Хороо, Далайн орчныг хамгаалах Хороо, Техникийн хамтын ажиллагааны Хороо, Зохицуулах Хороо болон Байгууллагын харъяа газруудын саналыг харгалзан Ерөнхий нарийн бичгийн даргын боловсруулсан ажлын хөтөлбөрийн болон төсвийн төслүүдийг авч хэлэлцээд Байгууллагын нийтлэг ашиг сонирхол, тэргүүлэх чиглэлийг анхааран үзэж Байгууллагын ажлын хөтөлбөрүүд ба төсвийн төслийг батлуулахаар Ассамблейд танилцуулна.

(б) Зөвлөл нь Далайд аюулгүй байдлыг хангах Хороо, Хуулийн Хороо, Далайн орчныг хамгаалах Хороо, Техникийн хамтын ажиллагааны Хороо, Зохицуулах Хороо болон Байгууллагын харъяа газруудын тайлан илтгэл, санал, зөвлөмжийг хүлээн авч тэдгээрийг Ассамблейд хэлэлцүүлэх ба харин Ассамблей хуралдаагүй үед өөрийн санал шүүмжлэл, зөвлөмжийн хамт мэдээллийн журмаар байгууллагын гишүүдэд хүргүүлнэ.

(в) Зөвлөл нь 28, 33, 38, 43 ба 48 дугаар зүйлүүдийн хамрах хүрээний асуудлыг нөхцөл байдлаас нь хамааруулан Далайд аюулгүй байдлыг хангах Хороо, Хуулийн Хороо, Далайн орчныг хамгаалах Хороо, Техникийн хамтын ажиллагааны Хороо, Зохицуулах Хороо болон Байгууллагын харъяа газруудаас тэдгээр асуудлаар дүгнэлт санал авсны дараа зөвхөн авч хэлэлцэнэ.

25 дугаар зүйл

“б) хэсгийн эх бичвэр дараахь байдлаар солигдоно:

“б) XVI хэсгийн заалт болон 28, 33, 38, 43 ба 48 дугаар зүйлүүдийн дагуу зохих Хороодоос бусад байгууллагатай харилцах асуудлыг Ассамблейн чуулганы хуралдааны хоорондох хугацаанд Зөвлөл хариуцна.

XI дүгээр хэсэг

Дараахь шинэ эх бичвэрийг оруулна:

Зохицуулах хороо

47 дугаар зүйл

Зохицуулах хороо Байгууллагын бүх гишүүдээс бүрдэнэ.

48 дугаар зүйл

Зохицуулах хороо нь Байгууллагын эрхлэх үйл ажиллагааны хүрээнд далайн олон улсын замын хөдөлгөөнийг хөнгөвчлөхөд хамааралтай аливаа асуудлыг хянан зохицуулах ба нэн ялангуяа:

(а) энэхүү үүргийг Байгууллагатай зөвлөлдөж буюу далайн олон улсын замын хөдөлгөөнийг хөнгөвчлөх зохицуулах талаар батлагдсан олон улсын гэрээ, конвенциудийн дагуу, тэдгээр конвенциудын нөхцлийг хангасан, ялангуяа хүлээн зөвшөөрч баталсан болон арга хэмжээнүүдийн нэмэлт өөрчлөлт буюу бусад заалтуудад нийцүүлэн хэрэгжүүлнэ;

(б) Зохицуулах хороо 25 дугаар зүйлийн заалтыг харгалзан Ассамблей буюу Зөвлөлийн хүсэлтээр эсвэл хэрэв өөрийн ажил хэргийн ашиг сонирхолын үүднээс ийм үйлдлийг ашигтай гэж үзвэл Байгууллагын цаашидын зорилгод дэмжлэг болохуйц нягт хамтын ажиллагаа, харилцааг бусад байгууллагатай хөгжүүлнэ.

49 дүгээр зүйл

Зохицуулах хороо дараахь баримтыг Зөвлөлд танилцуулна:

(а) хорооноос боловсруулсан зөвлөмж, удирдамжууд;

(б) Зөвлөлийн өмнөх чуулганаас хойшхи хугацаанд Хорооноос хийсэн ажлын талаархи тайлан илтгэл.

50 дугаар зүйл

Зохицуулах хороо жилд нэгээс цөөнгүй удаа хуралдана. Хороо нь өөрийн удирдах албан тушаалтнуудыг жилд нэг удаа сонгох ба өөрийн ажиллах Дүрмийг батална.

51 дүгээр зүйл

Зохицуулах хороо нь олон улсын аливаа нэгэн гэрээ, конвенцийг үндэслэн буюу тэдгээр гэрээ, конвенциор болон бусад баримт бичгээр түүнд хүлээлгэсэн үүрэг функцийг 47 дугаар зүйлийн заалтуудыг сахин мөрдөж хэрэгжүүлэх үед энэхүү Конвенцийн заалттай зөрчилдөх аливаа нэгэн асуудал гарвал тухайн олон улсын гэрээ, конвенци буюу баримтын зохих заалтуудыг тухайлбал, сахин мөрдөж биелүүлэх шаардлагатай ёс горим, журам зааврыг тогтоож буй дүрмийг баримтална.

56 дугаар зүйл (61 дүгээр зүйл болгож өөрчлөн дугаарласан)

Эх бичвэр дараахь байдлаар солигдоно:

“Байгууллагын өмнө хүлээсэн санхүүгийн үүргээ төлбөрийн хугацаа эхэлсэн өдрөөс хойш нэг жилийн хугацаанд барагдуулаагүй Байгууллагын аливаа гишүүний, хэрэв Ассамблей өөрийн үзэмжээр энэхүү үүргээс чөлөөлөөгүй бол, Ассамблей, Зөвлөл, Далайд аюулгүй байдлыг хангах Хороо, Хуулийн Хороо, Далайн орчныг хамгаалах Хороо, Техникийн хамтын ажиллагааны Хороо, Зохицуулах Хорооны хуралдаанд санал өгөх эрхийг хасна.

57 дугаар зүйл (62 дугаар зүйл болгож өөрчлөн дугаарласан)

Эх бичвэр дараахь байдлаар солигдоно:

“Хэрэв энэхүү Конвенци буюу олон улсын аливаа гэрээ, конвенцид өөрөөр заагаагүй бол Ассамблей, Зөвлөл, Далайд аюулгүй байдлыг хангах Хороо, Хуулийн Хороо, Далайн орчныг хамгаалах Хороо, Техникийн хамтын ажиллагааны Хороо, Зохицуулах Хороонд санал хураахад дараахь журмыг баримтална. Үүнд:

(а) байгууллагын нэг гишүүн нэг санал өгөх эрхтэй;

(б) санал хураалтад хүрэлцэн ирсэн болон оролцож буй Байгууллагын гишүүдийн олонхийн саналаар шийдвэр гаргах ба шийдвэр гаргахын тулд дийлэнх олонх буюу 2/3-ын санал шаардлагатай тохиолдолд Байгууллагын хүрэлцэн ирсэн гишүүдийн дийлэнх олонхийн буюу 2/3-ын саналаар гаргана;

(в) энэ Конвенцийн зорилгод “санал хураалтад байлцсан буюу санал өгсөн гишүүд” гэж санал хураалтад байлцсан, шийдвэр гаргах санал хураалтад “дэмжсэн” эсхүл “үгүй” санал өгсөн гишүүдэд хамаарна. Түдгэлзсэн гишүүнийг санал хураалтад “оролцоогүй” гэж үзнэ.

Нэмэлт ба өөрчлөлтүүдээс улбаалан орж буй

нэмэлт, өөрчлөлтүүд

5, 6, 7 дугаар зүйлүүд

71 дүгээр зүйлийн заалт 76 дугаар зүйлийн заалт болж солигдоно.

8 дугаар зүйл

72 дугаар зүйлийн заалт 77 дугаар зүйлийн заалт болж солигдоно.

15 дугаар зүйл

XII хэсгийн (g) заалт XIII хэсгийн заалт болж солигдоно.

25 дугаар зүйл

XV хэсгийн (a) заалт XVI хэсгийн заалт болж солигдоно.

XI – XX хэсгүүд

XI – XX хэсгүүдийг XII – XXI хэсгүүд гэж шинэчлэн дугаарлана.

47-77 дугаар зүйлүүд

47-77 дугаар зүйлүүдийг 52-82 дугаар зүйлүүд гэж шинэчлэн дугаарлана.

66 дугаар зүйл (71 дүгээр зүйл гэж шинэчлэн дугаарлана)

73 дугаар зүйлийн заалт 78 дугаар зүйлийн заалт болж солигдоно.

Хавсралт II

65 дугаар зүйлийн гарчгийн заалт 70 дугаар зүйлийн заалт болж солигдоно.

67 ба 68 дугаар зүйлүүд

(72 ба 73 дугаар зүйлүүд гэж зохих ёсоор шинэчлэн дугаарлана)

66 дугаар зүйлийн заалт 71 дүгээр зүйлийн заалт болж солигдоно.

70 дугаар зүйл (75 дугаар зүйл гэж шинэчлэн дугаарлана)

69 дүгээр зүйлийн заалт 74 дүгээр зүйлийн заалт болж солигдоно.

72 дугаар зүйл (77 дугаар зүйл гэж шинэчлэн дугаарлана)

71 дүгээр зүйлийн (d) заалт 76 дугаар зүйлийн заалт болж солигдоно.

73 дугаар зүйл (78 дугаар зүйл гэж шинэчлэн дугаарлана)

72 дугаар зүйлийн (b) заалт 77 дугаар зүйлийн заалт болж солигдоно.

74 дугаар зүйл (79 дүгээр зүйл гэж шинэчлэн дугаарлана)

71 дүгээр зүйлийн заалт 76 дугаар зүйлийн заалт болж солигдоно.

[1] Тус Конвенцийн 66 дугаар зүйлд нийцүүлэн сайшааж Далайн олон улсын байгууллагын Ерөнхий Ассамблейн (А.724(17)-377 Шийдвэр) чуулганаар хүлээн зөвшөөрч батлав.